

**Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын
мэргэжлийн үг, хэллэгийн хувьсал, хэрэглээ**

*Нарангийн АМАРТҮВШИН**
Монгол Улс, Улаанбаатар,
Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн,
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар

Received: May 30, 2025 | **Accepted:** October 16, 2025 | **Published:** December 30, 2025

***Хураангуй:** Дэлхий нийтээрээ цахим эринд шилжсэн энэ үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт шинэ ухагдахуун өдөр бүр шинээр төрж түүнийг нэрлэсэн мэргэжлийн үг, хэллэг байнга нэмэгдэж байна. Цахим орчны үгийн сан тасралтгүй баяжиж байгааг монгол хэлнээ үгчлэх, утгачлах, дүйцүүлэх, шууд зээлдэх, холимог үг бүтээх, шинэ үг бүтээх зэрэг аргаар орчуулсныг харьцуулан судлав. Монгол Улсын Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн түүхийг салбарын мэргэжлийн үг, хэллэгтэй нь хамт уялдуулж тайлбарлав.*

***Түлхүүр үг:** Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэргэжлийн үг, хэллэг, жаргон, орчуулга*

* © Н. Амартүвшин, 2025

Email: amartuvshin@mas.ac.mn,  <https://orcid.org/0009-0004-2493-8041>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Evolution of Professional Words and Phrases in Communications and Information Technology

AMARTUVSHIN Naran

Department of Applied Linguistics,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: *As the global community enters the digital era, new concepts continually emerge in the fields of communications and information technology, leading to the constant expansion of specialized terminology and expressions. This study presents a comparative analysis and evaluation of the ways in which the ever-growing digital lexicon has been translated into Mongolian, employing strategies such as lexicalization, semantic adaptation, equivalence, direct borrowing, hybrid word formation, and neologism creation. Furthermore, the historical development of communications and information technology in Mongolia is examined in relation to the sector's professional terminology and phrases, with corresponding explanations provided.* Ulaanbaatar, Mongolia

Keywords: *communications, information technology, technical terminology, jargon, phrases, translation*

1. Удиртгал

Хүн төрөлхтөн мэдээллийн технологи, харилцаа холбооны үсрэнгүй хөгжилтэй нүүр тулгарч байна. Энэхүү хөгжил нь зөвхөн техник, технологиор тогтохгүй тухайн технологийн салбарын мэргэжлийн хэлтэй холбогдоно.

Хамгийн анхны компьютер гэж хэлж болох ENIAC нэртэй тусгай хэрэглээний машиныг 1945 онд бүтээсэн нь нэг том танхимыг дүүргэсэн овор хэмжээтэй, 30 метр урт, 30 тонн жинтэй нэг орон сууцны хорооллыг хангах хэмжээний цахилгаан зарцуулдаг байжээ. Үүнээс хойш иргэд, аж ахуйд зориулсан ерөнхий хэрэглээний Kenbak-1, Altair 8800 гэх мэт дэлгэц, гаргүй тэжээлийн эх үүсвэрийг нь механикаар тасалж унтраадаг болхи хэлбэрийн компьютерүүд 1970-аад оны дунд үеэс буюу ENIAC-аас 30-аад жилийн хойно бүтээгдсэн нь ХХМТ-ийн хөгжил эхэн үедээ хэдий чинээ удаан байсныг харуулдаг.

1977 онд Apple корпорацаас гаргасан Apple II нь дэлгэц, keyboard – гар, хатуу диск буюу өгөгдөл хадгалах төхөөрөмжтэй гарсан нь одоогийн бидний хэрэглэж байгаа ердийн хэрэглээнд зориулсан анхны компьютер болжээ. Үүнээс өмнө нь бүтээгдсэн загваруудтай харьцуулахад хувь хүн, байгууллагын өргөн хэрэглээнд хамгийн амжилттай нэвтэрчээ.

2007 онд мөн л Apple корпорацаас утас, компьютерыг нэгтгэсэн ухаалаг утсыг өргөн хэрэглээнд нэвтрүүлсэн нь Харилцаа холбоо, Мэдээллийн технологи

хоёрыг бодитоор нэгтгэж нэг гарт багтаажээ. Энэ үйл явдал нь ХХМТ-ийн хэрэглээ, хөгжилд огцом тэсрэлт болсон юм. Тэр мөчөөс эхлэн “2025 оны байдлаар интернэт хэрэглэгчдийн дөнгөж 10% орчим нь суурин болон зөөврийн компьютероор холбогдож байгаа бол үлдсэн 90% гаруй нь гар утаснаасаа орж байна гэсэн судалгаа гарсан байна” (Kemp, 2025).

Ийнхүү интернэт сүлжээ, холбоо харилцааны дэд бүтэц, технологийн хэрэглээ улам хялбар болсноор олон нийтийн харилцаа, боловсрол, эдийн засаг цахим горим руу тасралтгүй шилжиж үүнээс үүдэлтэйгээр “нийгмийн сүлжээний платформууд, төрөл бүрийн аппликейшны хэрэглээ геометр прогрессоор өсөж байна” (Kemp, 2025). “Хүн төрөлхтний аж төрөхүй биет орчинтойгоо зэрэгцэн цахим орчинд өрнөх болсноор улс, үндэстнүүдийн ХХМТ-ийн салбарын мэргэжлийн үгийн сан урьд өмнө байгаагүйгээр эрчимтэй арвижин, шинэчлэгдэв” (Dor, 2015). Монгол хэлний хувьд энэ байдлаас тойрч гарахгүй нь ойлгомжтой бөгөөд мэргэжлийн үг, хэллэг, нэр томьёог зөв орчуулах, боловсруулах, оноон тогтоох, стандартчилах, журамлах нь цаг үеийн тулгамдсан асуудал болжээ.

Дээрх асуудлыг авч үзэхийн өмнө Монгол Улсын ХХМТ-ийн салбарын нэр томьёо, мэргэжлийн үг, хэллэгийн судалгааг орчуулга, хэрэглээ, уламжлал, шинэчлэл талаас нь шат дараалан хийх нь зүйтэй бөгөөд энэхүү өгүүлэлдээ монголчуудын ХХМТ-ийн салбарын түүхэн хөгжил, үгийн сангийн хувьсал, тасралтгүй шинээр нэвтэрч буй мэргэжлийн үг, хэллэгийн орчуулга, хэрэглээг авч үзэв. Энэхүү судалгаа нь зөвхөн хэл шинжлэлийн ач холбогдолтой бус, бодлого боловсруулах, боловсрол, шинжлэх ухаан, эдийн засаг, аж үйлдвэрлэл, бизнесийн орчинд хэрэгцээтэй гэж үзэж байна.

“Мэргэжлийн үг” гэдэг нь тодорхой салбар, ажил мэргэжлийн хүрээнд хэрэглэдэг мэргэжлийн онцлогтой ухагдахуун, үйл ажиллагаа, багаж хэрэгсэл, технологи зэргийг нэрлэсэн тусгай үг хэллэгийн нэр юм. Эдгээр үг нь тухайн салбарын мэргэжилтнүүдийн хооронд ойлголцлыг хялбарчилж, мэдээллийг нарийвчлан дамжуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ард нийтийн ердийн хэлэнд түгээмэл хэрэглэдэггүй боловч тухайн салбар нийтэд танигдахын хэрээр хэрэглээ нь нэмэгддэг жамтай. Мэргэжлийн үг нь дараах онцлогтой.

Үүнд:

- хязгаарлагдмал хэрэглээтэй (зөвхөн тухайн мэргэжлийн хүрээнд хэрэглэдэг).
- нарийвчилсан утгатай (энгийн үгнээс ялгаатай нь мэргэжлийн үг нь их тодорхой, нарийн утгыг илэрхийлдэг).
- техникийн шинжтэй (мэргэжлийн үг нь тухайн салбарын онцлогийг илтгэсэн техникийн, шинжлэх ухааны утга илэрхийлдэг байдаг).
- ойлголтын нэгдмэл байдал бий болгодог.
- орчуулга хийхэд төвөгтэй (зарим мэргэжлийн үг нь өөр хэлнээ орчуулахад утга алдагдах магадлалтай байдаг тиймээс тухайн салбарын орчуулга хийхэд мэргэжлийн мэдлэг шаарддаг).

- хувирамтгай (шинэ технологи, онол, аргачлал гарч ирэхийн хэрээр мэргэжлийн үг ч шинэчлэгдэж, өөрчлөгдөж байдаг).

“Жаргон” хэмээх үг нь тодорхой нэг бүлэг, мэргэжил, соёлын хүрээнд хэрэглэдэг тусгай үг хэллэг, хэлцийн нэр болно. Жаргоныг жирийн хүн шууд ойлгохгүй байх нь нийтлэг. Албан ёсны толь бичигт оруулан журамлаагүй тухайн бүлгийн хүмүүсийн хоорондын ойлголцлыг хялбаршуулах, эсвэл өөр бүлгээс өөрсдийгөө ялгах, янз бүрийн соёлын түвшний дотоод орчныг бүрдүүлэх зэрэг үүргээр хэрэглэдэг. Жаргон нь дараах онцлогтой.

Үүнд:

- Товчилсон хэллэг ихтэй.
- Соёлын онцлог, цаг үеийн ялгаа илэрхийлдэг.
- Хязгаарлагдмал хэрэглээтэй (*Жаргон нь тухайн бүлэг дотор ойлгомжтой гаднын хүмүүст төдийлөн ойлгомжгүй*).
- Тусгай үг хэллэгтэй (*Жаргон үгс нь ихэвчлэн уран дүрслэлтэй, товчилсон, эсвэл шинээр зохиосон байдаг*).
- Хэлний бүтцийн хувьд өөрчлөлттэй (*Утга шилжилт, метафор, дуу авианы хасалт нэмэлт, гадаад үгийг зээлдэх зэрэг аргаар үүсдэг*).
- Сэтгэл хөдлөл илэрхийлсэн (*Ярианд сэтгэл хөдлөл, хошин өнгө, уран яриа нэмдэг*).
- Нийгмийн ялгарал илэрхийлдэг (*Жаргон хэрэглэснээр тухайн хүн өөрийн бүлэгт хамааралтайг илэрхийлдэг. Жишээ нь: залуусын жаргон, мэргэжлийн жаргон, гэмт хэргийн арго гэх мэт*).
- Харилцааг хялбарчилдаг.

Монголчуудын хувьд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар одоогийн үе улиран амьдарч ирсэн нутаг орондоо төрт ёс үүсгэн бий болгосон цагаас улбаалан хөгжиж ирсэн нь гагц түүхэн сурвалжуудаар тогтохгүй, монгол хэлний үгийн сангаас илэрч гардаг. Монгол нутагт анх хэдийд төрт улс үүссэнийг баттай тогтоох эх сурвалж, материал үгүй бөгөөд одоогоор олдсон сурвалж, материал дээр үндэслэж судлаачид Хүннү гүрнээр тооцдог. Үүгээр авч үзвэл бидний харилцаа холбоо, мэдээллийн технологийн мэргэжлийн үгийн сан бүрэлдэх явц, түүхэн хөгжлийг даруй 2000 гаруй жилийн өмнөөс эхтэй гэж үзэж болно. Харин одоогийн Монгол Улсын Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн салбарын хөгжлийг улсын түүхэн үндэс, эхлэл болох Их Монгол Улс байгуулагдсан 1206 оны үеэс эдүгээг хүртэл буюу 2025 он хүртэлх хугацааг хамруулан тоймлон авч үзэв.

2. Судалгааны арга зүй

Монгол Улсын ХХМТ-ийн салбарын мэргэжлийн үг, хэллэгээс түгээмэл хэрэглээтэй үгсийг түүвэрлэх аргаар сонгон 300 үгтэй сан бүрдүүллээ. Тус сангаас ажиглах аргаар орчуулга, хэрэглээг тодруулж, өөрийн орчуулсан хувилбарыг тайлбарлан санал болгов. Монголын Нууц Товчооны хэл шинжлэлийн судалгаанд зориулсан хөрвүүлэг, хувилбарууд болон Хорин нэгт

тайлбар толь, Алтан товч зэрэг сурвалж материалуудаас монголчуудын ХХМТ-ийн салбарын түүхэн хөгжил, уламжлалт үгсийг тоочих аргаар дурдан хам болон цуваа цагийн, түүхэн харьцуулсан аргуудаар хэлний хөгжил, утгын өөрчлөлт, үгийн гарлын судалгаа хийв.

3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үг, хэллэгийн түүхэн хөгжил

Монголчуудын дунд Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үг, хэллэг нь үгийн сангийн түвшинд Төв Азид эртний төрт улсууд үүсэн бий болсон цагаас хэрэглэгдэж байсан гэж хэлж болно. *Тухайлбал нийтийн тооллын III зууны сүүлч II зууны эхнээс Хүннү улсад “Оуто ван” буюу өртөө ван хэмээх албан тушаал байжээ. Уг гүрний вангууд эзэн хаандаа яаралтай бичгүүдийг уургын улаа хэрэглэн буухиа элчээр явуулж эхэлснээр шуудан холбооны эх үүсвэр тавигдсан түүхтэй. Мөн III зууны сүүлч II зууны үед Хүннү нар гадаадад элч зарж, бичиг илгээж байсан мэдээ бий. Нийтийн тооллын IV зуунд “өртөөчин” хэмээх албан тушаал бий болж, улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан өртөө байгуулж эхэлсэн (Төмөрхүү., Намсрай, 2011).*

Их Монгол Улсын үеэс улбаалан түүхэн цаг хугацаанд нэмэгдэн баяжиж эсвэл солигдон хувирч ирсэн ХХМТ-ийн мэргэжлийн үг арвин бөгөөд тухайлбал “гэрэгэ”, “зам”, “өртөө”, “тай”, “улаа”, “утаат дохио”, “харуул толгой”, “мөр” зэрэг нь түүхийн үе шат бүрт ХХМТ-ийн мэргэжлийн үгсийн үүрэг гүйцэтгэж байжээ гэж үзэж болно. Утаат дохио нь мэдээлэл дамжуулах технологи бол түүний дэд бүтэц нь харуул толгой юм. Өртөөг нэг талаас мэдээлэл дамжуулах ерөнхий сүлжээний нэгж нөгөө талаас технологи, өртөөний тайг хаб буюу сүлжээний зангилаа гэж үзэж болно. “Өртөөний суурь тутамд аливаа албыг залгуулж нийлүүлэх бэлтгэлийн “өртөөний тай” хэмээх газар байв” (Төмөрхүү., Намсрай, 2011).

Тэр үед өртөөг “зам” гэдэг байсныг доор дурдвал: МНТ 279§: “Эдүгээ бид огоот оршуулан, зүг зүгийн мянгад мянгадаас замчин, улаачин гаргаж, суурин сууринд зам тавьж, элчийг хамаагүй улсаар үл бидүүлэн, замаар уулгаваас (уулгалбаас) болох бус уу” гэсэн өгүүлбэрт дурдагдах “зам” нь тэр үеийн өртөөг нэрлэсэн үг байжээ. Энэ монгол үг нь хятад, орос зэрэг хэлэнд өртөө хэмээсэн утгаараа орсон буй. Орчин цагийн монгол хэлний “зам” нь өртөө гэсэн утгаа гээгээд харин дунд үеийн монгол хэлний “мөр” хэмээсэн утгаар хэрэглэх болжээ. Замаар – өртөөгөөр, замууд эсрэг барилдуулсугай – угтуулан олон өртөөг байгуулсугай, эсрэг замуудаа –өөдөөс нь өртөөгөө (Чоймаа, 2011). Мөн 279-р зүйлд “замууд талбиулах” хэмээснийг МНТ эрдэм шинжилгээний хөрвүүлэг бүтээлд “өртөө байгуулах” хэмээн тайлбарласан байдаг (Мөнхсайхан, 2024). Өдрийн цагаар богино зайд “дарцагт дохио”, холын зайд “утаат дохио”-г хэрэглэдэг байсан бол шөнийн цагаар “галт дохио”, далдаас “дуут дохио”-г ашигладаг байжээ. Төрлөөр нь нарийвчлан галт, утаат, дарцагт, дуут дохио гэж

анги́лан нэрлэсэн нь мэргэжлийн үгээс давж ХХМТ-ийн ухагдахуун илэрхийлсэн нэр томьёоны үүрэгтэй болжээ. Дээрхийн адил өртөөг мөн дотор нь анги́лан ялгаж нэр томьёожуулж байсныг XVII- XVIII зууны жишээгээр энд дурдвал: *XVII зууны сүүлч XVIII зууны эхэнд олон хошуудын засаг захиргааны газрыг байгуулж, орон нутгийн дотор харилцан нэвтрэлцэх явдлыг залгуулахын тулд тэдгээр газруудын дэргэд морин өртөөдийг нэмж байгуулжээ. Эдгээр морин өртөөд нь олон замын буухиа өртөөнөөс тусдаа байгуулагдсан бөгөөд “Орон нутгийн морин өртөө” гэж нэрлэгдэж байв. Энэхүү орон нутгийн морин өртөөг “суман өртөө” гэх бөгөөд түүнээс салбарласан өртөөдийг “салбар”, “дамжлага”, “навч” өртөөд гэж нэрлэжээ. Өртөөний албан хаагчдыг “тахар”, “зарлага мэдээ”, “уяачин” гэх зэргээр нэрлэдэг байв* (Төмөрхүү., Намсрай, 2011).

“Элч”, “дохоч”, “улаач”, “замчин” зэргийг орчин цагийн “холбоочин”, “оператор”, “IT-ийн ажилтан” зэрэг мэргэжлийн эртний хувилбар гэж үзэх боломжтой. Эдгээр нь бүгд тухайн үеийн мэдээллийн технологийн салбарт ажиллагсдыг нэрлэсэн мэргэжлийн үг болно.

МНТ 37§: *“Alginci ha’ulgaqaba”* буюу “алгинч агуулгав” хэмээснийг “толгойн туршуул болгон довтолгов” (Чоймаа, 2011), “түрүүлэн илгээв” (Мөнхсайхан, 2024) “алгинч”-ийг “толгойн харуул, туршуул” (Мөнхсайхан, 2024) гэж тайлбарласан байдаг.

Лу. Алтан товчийн дундад зууны үеийн тухай өгүүлсэн хэсэгт гарах дайлаар мордох цэргээс салангид явж буй “агулагчин” буюу “уулчин”-ний бичвэр дэх утга мөн алгинчтай дүйж байна. “Алгинч”, “агулагчин” нь цэргийн үндсэн бүрэлдэхүүнээс түрүүнд эсвэл ангид захлан явж газар орчин, нөхцөл байдлыг тандан судлаад удирдлагад мэдээ дамжуулдаг тагнан турших цэргийг нэрлэдэг байсан нь мөн ХХМТ-ийн мэргэжлийн үг гэж үзэх бололцоотой.

МНТ-д тохиолдох “хэл оруулах” (нууц мэдээлэл дамжуулах), “дуу бариулах” (аман захидал хүргэх) гэх мэт үгсийг тэр цагийн харилцаа холбооны салбарын жаргон гэж хэлж болно. МНТ 170§, 196§: *“Kele oro’ulju”* буюу “хэл оруулж” гэснийг “илгээж буй аман мэдээг хүнд мэдэгдэхгүй сэм хүргэх” (Мөнхсайхан, 2023). МНТ 177§, 199§: *“Dawu bari’ulurun”* буюу “дуу бариулруун” хэмээснийг “урт аман мэдээг цээжлэн хол зайд хүргэх” (Мөнхсайхан, 2024) “хүргэх хэл мэдээг элчид тогтоолгох” (Чоймаа, 2011) гэж тайлбарласан. Энд нууц мэдээг аман хэлбэрээр хүргэхийг “хэл оруулах”, нууц биш мэдээг эсвэл захидлыг аман хэлбэрээр зарлан өгүүлэхийг “дуу бариулах” хэмээн хийсвэр утгаар зүйрлэжээ.

Дундад зуунд хоёр өртөөний хооронд мэдээлэл дамжуулах туслах улаачийг “холбогч” гэдэг байсан бол XX зуунд хоёр станцыг радио дохиогоор холбогчийг “холбоочин” гэж нэрлэв. Мэдээллийн технологийн нэр томьёо, мэргэжлийн үг салбарынхаа онцлогтой уялдаад асар хурдтай шинэчлэгдэн хувьсаж байдгийн жишгээр хэлний хэрэглээнд саяхан идэвхтэй, нийтийн дунд түгээмэл хэрэглээтэй байсан энэхүү “холбоочин” гэдэг үг одоо хэрэглээнээс гарчээ.



Зураг 1. Холбоочин (<https://www.zindaa.mn/3kn9>)

XVIII зууны үед “сэтгүүл” хэмээх үг цэрэг, батлан хамгаалахын салбарын харилцаа холбооны мэргэжлийн үг байсан бол дараа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр болжээ. 1717 оны “Хорин нэгт тайлбар толь”-д цэргийн хэрэгт довтлох хүнийг “сэтгүүл” хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 1977) гэж тайлбарласан байдаг. Түүнчлэн дайсныг дарсан баярын мэдээг дээр сонсгон айлтгахыг “сэтгүүл довтолгомуй” (Хорин нэгт тайлбар толь, 1977) гэсэн байна. Үүнээс үзэхэд, мэдээ хүргэгч цэрэг гэдэг нь “сэтгүүл” хэмээх үгийн анхдагч утга юм. Мэдээ хүргэгч цэрэг гэсэн утгаас улирч хувьсан, өдгөө тогтмол гардаг хэвлэлийг “сэтгүүл” хэмээх болжээ. Хорин нэгт тайлбар толийн “сэтгүүл” хэмээх үгийн тайлбарыг орчин цагийн ойлголттой жишиж үзэхэд, сэтгүүлч мэргэжилтэй тун ойр дүйж байна. Монгол бичгийн хэлнээ Мо. sedkülči “сэтгүүлч” гэж тохиолдох бөгөөд мэдээ хүргэгч цэрэг гэсэн утгатай сэтгүүл (Мо. sedkül) хэмээх язгуурт ажил мэргэжлийн утга илтгэх -ч (Мо. či) дагавар залгаж, сэтгүүлч хэмээх үг бүтжээ. Сэтгүүл цэрэг хэмээх үгтэй бүтцийн хувьд төстэй *хэвтүүл цэрэг* хэмээх үг бий бөгөөд МНТ §191: kehte”ül “хэвтүүл” гэж тохиолдоно.

Эндээс мэдээ хүргэгч цэрэг буюу хуучин цагийн ХХМТ-ийн ажилтны нэр орчин цагт хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр болж түүнд дахин ажил мэргэжлийн утга илтгэх дагавар залгаснаар “сэтгэ+үүл+ч” буюу бас нэг ХХМТ-ийн ажилтны нэр үүсжээ гэж ойлгож болох юм. “Сэтгүүл” хэмээх үгийг Монгол хэлний их тайлбар толь-д: *1.1. Ямар нэгэн тусгай мэргэжлийн тухай юм уу ямар нэгэн асуудлын утга учир, чанар, байдал зэргийг олон нийтэд таниулах зорилготой тогтмол хэвлэл; 2. [хуучирсан] Цаг үеийн байдлыг гаргах богино хэмжээний баримтат кино гэж үндсэн болон салаа утгыг нь тайлбарлажээ. Мөн II. Цэргийн хэрэгт довтлох хүн (mongoltoli.mn)* гэсэн утгатай тохиолдоно (тус толь бичигт араб тоогоор үгийн үндсэн болон салаа утгыг, ром тоогоор ижил үгийг тайлбарладаг).

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэдээллийн платформ дээр Монгол Улсад орчин цагийн Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн салбар өдгөөгөөс 104 жилийн өмнө буюу 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын 6 дугаар хурлаар шуудан бичиг цахилгаан мэдээний хороог байгуулж, Хиагтын цахилгаан мэдээний хорооны түшмэл байсан гүн Цэдэвсүрэн гуайг ерөнхийлөн захирах түшмэлээр нь томилсноор өнөөдрийн Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн салбар байгуулагдсан түүхтэй. Энэхүү түүхт өдрийг өнөөдөр бид “ХОЛБООЧДЫН БАЯР” хэмээн нэрлэж, тэмдэглэн өнгөрүүлдэг болсон уламжлалтай (ЦХИХХЯ, 2025) гэжээ. Харин түүх сөхвөл, 1890-ээд оны үед Манж Чин Улсаас Газрын шуудан холбооны хэлтэс хэмээх газрыг Өргөө (Их Хүрээ)-д байгуулан улмаар 1910 онд Хаант Орос, Чин гүрний хооронд хийсэн шуудан холбооны хэлцлийн дагуу Өргөө хотод гурван улсыг холбосон цахилгаан мэдээ дамжуулах шугам тавьсан байдаг. Энэ нь монголчуудын хэрэглээнд нэвтэрсэн орчин цагийн харилцаа холбооны анхны систем байсан бол, 1911 онд Монгол Улс Чин гүрнээс салж тусгаар тогтнолоо сэргээсний дараагаар Гадаад хэргийн сайд Чин Ван Ханддорж 1912 онд Нийслэл хүрээний цахилгаан мэдээний хороог байгуулсан нь Монгол Улсын орчин цагийн харилцаа холбооны салбарын эхлэл болжээ. 1914 онд Сайн ноён хан Намнансүрэн Хаант Орос Улсад гурван сар зочлохдоо телефон утасны аппарат авчирч одоогийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр Бөхийн өргөөний баруун талд баригдсан ногоон барилгад суурилуулсан нь Монгол Улсын телефон утасны холбоо харилцааны эхлэл болсон. 1914 оны арван хоёрдугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын орчин цагийн харилцаа холбооны хууль эрхзүйн актыг “Өргөө хотын Монгол Улсын телефон сүлжээ ашиглах дүрэм” хэмээх нэрээр баталж байжээ.



Зураг 2. Монгол Улсын анхны телефон станцын барилга 1914 он (<https://www.zindaa.mn>)



Зураг 3. Монгол Улсын анхны телефон станцын барилга 2025 он (<https://www.zindaa.mn>)

Орчин цагийн харилцаа холбооны технологи хөгжсөн үеийг түүхчлэн авч үзвэл, анх 1890-ээд оны үед Манж Чин Улсаас газрын шуудан холбооны хэлтэс хэмээх газрыг Өргөө (Их Хүрээ)-д байгуулснаас эхэлдэг. Улмаар 1910 онд Хаант Орос, Чин гүрний хооронд хийсэн шуудан холбооны хэлцлийн дагуу Өргөө хотод гурван улсыг холбосон цахилгаан мэдээ дамжуулах шугам тавьжээ. Энэ нь Монгол Улсын цахилгаан холбооны анхны систем байжээ. Үүнтэй холбоотой “төмөр утас цохих”, “утасны шон”, “шонгийн мод” гэх мэт жаргоныг хэрэглэж байв. Манж Чин гүрний эрхшээлд байх үед монгол хэлнээ нэвтэрсэн харилцаа холбооны нэр томъёо социалист утга зохиолд найргийн мөр, зохиолын хэллэг болон “уушаан дэн”, “төмөр утас цохих” гэхчилэнгээр үлджээ. “Уушаан дэн” гэдэг нь Хүрээнд байсан Хятадын цахилгаан мэдээний газрын цамхгийн нэр юм (НЭПКО, 2019). Мөн тэр үед “утас”, “утсаар ярих” хэмээх жаргон нь иргэдийн харилцаа холбооны дэд бүтэц, төхөөрөмжийг харах өнцгөөс үүсэн бий болсон нь хожмоо мэргэжлийн үг болж явцын дунд ХХМТ-ийн нэр томъёо болжээ.

Монголчуудын өөрсдийн эзэмшлийн анхны шуудан холбооны тогтолцоог Гадаад хэргийн сайд Чин Ван Ханддорж 1912 онд Нийслэл хүрээнд цахилгаан мэдээний буюу морзын хороог байгуулснаар эхлүүлсэн бол анхны телефон станцыг 1914 онд ерөнхий сайд, Сайн ноён Хан Т. Намнансүрэн Хаант Оросоос авчирч одоогийн Бөхийн өргөөний хажуугийн ногоон байшинд суурилуулж байжээ. Энэхүү түүхэн барилга одоог хүртэл тэр үеийн хэлбэрээ хадгалан музейн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

1924 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхны радиостанц, телеграф, телефон холбооны шугамууд тавигдаж, 1930-аад оноос шуудан, цахилгаан холбооны станцуудыг хөдөө орон нутагт олноор нь байгуулжээ. 1940-өөд оноос утасгүй холбоо, радио холбоо өргөжин хөгжиж бүх аймаг, сумдыг утас, телеграф, радио сүлжээнд холбожээ.

1981 онд Монгол Улсад хиймэл дагуулын холбооны систем ашиглалтад орсноор олон улсын харилцаа холбооны мэргэжлийн үгс монгол хэлнээ нэвтэрч эхэлсэн гэж үздэг. 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжихтэй зэрэгцэн харилцаа холбооны салбарт хувьчлал, өрсөлдөөн бий болж, технологийн шинэчлэл хурдассан. 1995 онд гар утас, интернэт үйлчилгээний эхлэл тавигдан 2000 оноос хойш “ICT” буюу “Мэдээлэл, харилцаа холбоо” хэмээх нэр томъёо ард иргэдэд танил болж түүний дагалдах салбарууд болох мобайл технологи, интернэт, шилэн кабель, дижитал радио, IP телевизийн үйлчилгээний мэргэжлийн үг, хэллэг англи хэлнээс нэвтэрч эхэлжээ.

“ICT” буюу “Мэдээлэл, харилцаа холбоо”-ны мэргэжлийн үг дэлхий нийтээр ерөнхийдөө англи хэл дээр өргөн тархсан байдаг бөгөөд Монгол Улсын харилцаа холбооны салбарт эхэн үедээ мэргэжлийн үгсийг англи хэлээр нь шууд хэрэглэх явдал түгээмэл байсан бол мэдээллийн технологи хөгжиж иргэдийн мэдлэг дагалдан нэмэгдэхийн хэрээр нэр томъёо, мэргэжлийн үг хэллэгийг монгол хэлээр орчуулан дүйцэх үгсийг нь олж хэрэглэх нь 2010-аад оноос эхэлжээ гэж болохоор байна. Монгол Улсад 4G LTE сүлжээ нэвтэрч, интернэтийн үйлчилгээ түүнд холбогдох төхөөрөмж, персональ компьютер (PC), ухаалаг гар утасны хэрэглээ түгээмэл болсноор нийгмийн амьдрал цахим орчин руу хурдацтай шилжин орох болсон бөгөөд уламжлалт хэвлэл мэдээллийн байр суурийг цахим орчинд дахь олон нийтийн сүлжээ, платформууд эзлэх болов.

Сүүлийн жилүүдэд Монгол Улс цахим шилжилтийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний олон платформыг нэвтрүүлэн 600 гаруй үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Мөн хиймэл оюун ухаан, их өгөгдөл, 5G сүлжээ зэрэг дэвшилтэт технологиудыг туршиж, нэвтрүүлж эхэлсэн. Монгол Улс цахим хөгжлөөрөө Азид 13, дэлхийд 46-д эрэмбэлэгдэж байгаа нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартайг нотлох бөгөөд түүнчлэн Тажикстан, Киргиз зэрэг Төв Азийн орнуудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан нь мэдээллийн технологийн компаниудын гадаад зах зээлд гарах чадамжтай болсныг харуулсан үйл явдал болжээ.

4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үг хэллэгийн орчуулга, хэрэглээ

Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үг хэллэгийн орчуулга, хэрэглээ нь нийгэм, технологийн хөгжлийг даган үе шаттайгаар бүрэлдэн тогтжээ.

I шат (1910 -1960 он): “Цахилгаан холбоо”, “станц”, “радио”, “холбоочин”, “монтёр”, “залгагч”, “телеграф”, “коммутатор” гэх мэт ажил мэргэжлийн үг монгол хэлнээ шинээр үүсэн бий болж орчуулалгүй шууд зээлдэн хэрэглэх нь түгээмэл байсан. Эхэндээ тусгай хэрэглээний үг байсан бол яваандаа ердийн хэрэглээний үг болжээ.

II шат: Харилцаа холбооны инженерчлэлийн суурь тавигдсан 1960—1989 онд нэг талаас харилцаа холбоо, мэдээллийн технологи хөгжин энэ салбарт ажиллагсад төдийгүй ард иргэдийн мэдлэг, боловсрол дээшилсэн нөгөө талаас УНТК (Улсын Нэр Томьёоны Комисс)-с шинжлэх ухааны салбар бүрийн нэр томьёог боловсруулах ажлын хүрээнд мэргэжлийн үгсийг орос хэлнээс монгол хэлнээ орчуулах ажил эрчимжжээ. Нэр томьёо боловсруулах явцад “*цахилгаан холбоо*”, “*холбооны шугам*”, “*долгионы зурвас*”, “*цагийн давтамж*”, “*долгионы үелэл*”, “*цахилгаан шуудан*”, “*цахилгаан илгээх* гэх мэт үгчлэн орчуулсан, “*электрон тооцоолуур*”, “*телевизийн суваг*”, “*радио долгион*” гэх мэт холимог, “*телефон станц*”, “*диспетчер*”, “*магистраль*”, “*антенн*” (*антенна*) гэх мэт шууд зээлдсэн нэр томьёо, мэргэжлийн үг бий болов. Тухайн үеийн техник технологи нь Зөвлөлт Холбоот Улсаас оруулж ирсэн тоног төхөөрөмж дээр суурилж байсан тул мэргэжлийн үг, нэр томьёог нь ихэвчлэн орос хэлнээс орчуулан хэрэглэдэг байсан.

III шат буюу шилжилтийн үе (1990—2010): Нийгэм эдийн засгийн шилжилт явагдаж олон улсад нээлттэй болсноор шинэ техник, технологи хурдацтай нэвтэрч олон улсад түгээмэл хэрэглээтэй англи хэлний мэргэжлийн үг, нэр томьёоны хэрэглээний эрин үе эхэлжээ. “*Файл*”, “*драйвер*”, “*принтер*”, “*сканнер*”, “*модем*”, “*сервер*”, “*браузер*”, “*вэб*”, “*инпүт*”, “*аутпүт*” зэрэг мэргэжлийн үгсийг шууд зээлдэн авч кириллээр галигласан нь эдүгээ монгол хэлний ердийн үг болжээ. Яваандаа иргэдийн англи хэлний мэдлэг, боловсрол дээшилснээр шинээр орж ирж байгаа ухагдахууныг илэрхийлсэн нэр томьёо, мэргэжлийн үгийг “*digital transformation*” - “*тоон шилжилт*”, “*open data*” - “*нээлттэй өгөгдөл*”, жаргоныг “*bug*” - “*алдаа*” (программ хангамж эсвэл техник хангамж дахь алдаа, доголдол, гүйцэтгэлийн зөрчил) хэмээн утгачилан эсвэл “*цох*” гэх мэтээр үгчлэн орчуулдаг болжээ. Мөн өмнө нь шууд зээлдсэн үгсийг ч зарим нэг талаар дүйлгэн орчуулах болов. Тухайлбал “*браузер*” хэмээн хэрэглэдэг байсныг “*вэб хөтөч*”, “*принтер*” - “*хэвлэгч*”, “*сканнер*” - “*хувилагч*”, “*инпүт*” - “*оролт*”, “*аутпүт*” - “*гаралт*” хэмээн хувилбарлан хэрэглэж байна.

Мэргэжлийн үгийг үгчлэх, утгачлах, шууд зээлдэх, дүйцүүлэх аргуудаар шинжлэх ухаан, техникийн нэр томьёо оноох үндсэн шаардлага болох товч (нэг юм уу хоёр үгээс, ихдээ гурван үгээс бүтсэн байх), оновчтой байх (тэмдэглэж буй цаад ухагдахууныхаа онцлог шинжийг тусгасан) зарчмыг баримтлан орчуулжээ.

IV шат буюу дижитал шилжилтийн үе (2010—одоог хүртэл): Дэлхийн нийтийн ажил, амьдралын хэв маяг биет орчноос цахим орчинд үсрэнгүй шилжсэн одоо цагийг хэлнэ. Энэ үед орж ирж буй харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үгс нь цахим орчин дахь нийгмийн сүлжээний жаргоноор баяжин орж ирж байна. Ухаалаг төхөөрөмж, хиймэл оюун ухаан (AI), үүлэн технологи, блокчэйн зэрэг шинэ ухагдахуун үүсэж, шинэ нэр томьёо, мэргэжлийн үгсийн орчуулга идэвхтэй болжээ. Зарим нэр томьёог

"cloud computing" - "үүлэн тооцоолол", "artificial intelligence" - "хиймэл оюун ухаан" гэх мэтээр шууд орчуулж, заримыг нь "биткойн", "блокчэйн", "app" гэх мэтээр кириллээр галиглан шууд зээлдэв. Нийгмийн сүлжээний төрөл бүрийн платформууд, хэрэглээний программ хангамжийн англи хэлний мэргэжлийн үгс олон нийтийн ярианы хэлэнд өргөнөөр хэрэглэгдэж байна.

Харилцаа холбоо, Мэдээллийн технологи нь шинжлэх ухаан, техник, инновац хамгийн хурдтай хөгжиж буй салбаруудын нэг бөгөөд үүнтэй уялдан шинэ нэр томьёо, мэргэжлийн үг хэллэг тасралтгүй бий болж байна. Эдгээр үг хэллэгийг монгол хэлэнд зөв, ойлгомжтойгоор орчуулах, нутагшуулах асуудал чухал ач холбогдолтой болжээ. ХХМТ-ийн салбарын нэр томьёо нь техник, технологи, программ хангамжийн нарийн ойлголтыг илэрхийлдэг учраас орчуулгын явцад утгын нарийвчлал алдагдах, эсвэл монгол хэлэнд тохирох үг олдохгүй байх хүндрэл түгээмэл тохиолддог ажээ.

4.1. ХХМТ-ийн мэргэжлийн үг, хэллэгийг орчуулсан үндсэн арга

ХХМТ-ийн мэргэжлийн үг, хэллэг нь ихэвчлэн товчлол (*app, ram, lan г. мэт*), адилтгал хэллэг (*bug, firewall, cookie г.мэт*), үйлдэх адилтгал (*crash, debug, boot г.мэт*), цахим иргэншлийн шинэ үг хэллэг (*googling, spamming, phishing г.мэт*) зэрэг үг зүйн ангиллаар илэрдэг. Мэргэжлийн үг, хэллэгийг монгол хэлнээ орчуулахад үгчлэх, утгачлах, дүйлгэх арга давамгайлж орчуулах боломжгүй үед кириллээр галиглан зээлдэх, тайлбарлан орчуулах, шинэ үг бүтээх аргыг хэрэглэсэн байдаг.

Хүснэгт 1. ХХМТ-ийн мэргэжлийн үг, хэллэгийн орчуулгын харьцуулалт

	Орчуулгын арга	Жишээ	Давуу тал	Сул тал
1	Үгчилсэн орчуулга (хуулбар орчуулга)	cloud computing - "үүлэн тооцоолол", mouse - "хулгана", worm - "өт"	Хэрэглэгчдэд ойлгомжтой, үгийн бүтэц монгол хэлний зүй тогтолтой нийцдэг.	Адилтгалын аргаар бүтсэн жаргоныг шууд үгчлэн орчуулахад ойлгомжгүй болж, жинхэнэ утгыг бүрэн илэрхийлэхгүй байх магадлалтай.
2	Утгачилсан орчуулга	Bug - "алдаа", debug - "алдаа засах", keyboard - "гар"	Үгийн хэрэглээний утга тодорхой, хэрэглэгчийн хэвшсэн ойлголтод дөхөм	Зарим адилтгалын аргаар бүтсэн жаргоны англи эхийн агуулга нь бүдгэрч болно
3	Галиглан зээлдсэн	Server - "сервер", browser - "браузер", app - "апп", bot - "бот"	Олон улсын шинж чанартай	Монгол хэлзүйн бүтцэд харьцангуй зөрчилтэй, утга нь тайлбаргүй бол ердийн хэрэглэгчдэд ойлгомжгүй байх магадлалтай

4	Дүйлгэх	Phishing - “урхидалт”, payload - “гэмт дайвар”, brute force – “муйхарлалт”	Гадаад нэр томьёоны үндсэн утга, үйл ажиллагааны мөн чанарыг монгол хэлний үгийн сан, дүрслэх боломжтой уялдуулан илэрхийлдэг. Ийм орчуулга нь нэр томьёог эх хэлний сэтгэлгээний хүрээнд ойлгох нөхцөлийг бүрдүүлж, хэрэглэгчдэд утгын хувьд илүү тодорхой, дүрслэл сайтайгаар хүрдэг.	Зарим тохиолдолд шинээр зохиосон дүйцүүлсэн үг нь нийтлэг хэрэглээ, төдийгүй мэргэжлийн хүрээнд хэвшдэггүй. Мөн олон улсын хэрэглээтэй нэр томьёотой шууд дүйхгүй тул гадаад эх сурвалжтай харьцуулахад ойлголтын зөрүү үүсэх, тайлбар шаардлагатай болох магадлалтай.
5	Шинэ үг бүтээх	Malware - “хорт программ”, spam - “хогон мэйл”, romance scam – “дурлалын залилан”	Олон улсын шинж чанартай мэргэжлийн ухагдахуун илэрхийлсэн үгээр үгийн сан баяждаг.	Зарим шинэ үг нийтийн хэрэглээнд түгэхэд хугацаа шаардана
6	Холимог орчуулга	Software update - “программ шинэчлэх”, file upload – “файл байршуулах”, app install - “апп суулгах”, server error- “сервер алдаа”	Мэргэжлийн ба ерөнхий хэл хооронд холбоо үүсгэдэг	Хувилбар орчуулга үүсдэг

Шинэ үг бүтээх арга нь тухайн үгтэй дүйцэх шинэ монгол үг бүтээхийг зорьдог. “Аливаа хэлний үүсмэл үг нь үүсмэл бус үгээс олон бөгөөд хэлэнд шинэ үг бүтээх хэд хэдэн түгээмэл арга байна. Монгол хэлний хувьд залгавраар шинэ үг бүтээх арга зонхилдог гэж судлаачид үздэг” (Томтогтох, 2012).

Мэргэжлийн үгсийг орчуулахдаа товчилсон ADSL, GPS, GSM, LAN, ERP, IPTV, VoIP гэх мэт нэр томьёог орчуулалгүй шууд латинаар нь эсвэл Эй Ди Си Эл, Жи Пи Эс, Жи Эс Эм, Лан, Ай Пи ТВ гэх мэтээр кириллээр галиглан хэрэглэж байна. Нэгэнт зээлдсэн үгсэд монгол хэлний дагавар залгах эсвэл холимог үг үүсгэж нутагшуулжээ. Дуудлагын хувьд браузер / браузэр, сервер / сэрвэр / сэрвер /сэрвэр зэрэг бичлэгийн хувилбар үүссэнийг нь жигдэлж журамлах нь чухал бөгөөд энэ талаар тогтсон дүрэм журамгүй судлаач, хүрээлэн, их сургуулиудын дунд хэлэлцүүлгийн түвшинд явж байна.

Гадаад үгийг авиан олон хувилбараар тэмдэглэсэн жишээ: Web- вэб / веб, software- софтвер / софтвер, application -аппликейшн / аппликэйшн

Гадаад үгийн эцсийн зөөлөрсөн гийгүүлэгчийг хувилбараар бичсэн жишээ: Магистраль / магистрал, модуль / модуль, кабель / кабел

Олон хувилбартай бичиж буйн шалтгааныг 2025 оны аравдугаар сарын 1-нд Улаанбаатар хотод болсон “Гадаад үг, оноосон нэрийг кириллээр хөрвүүлэх асуудалд” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр:

1. Эрх зүйн зохицуулалт байхгүй, хяналтгүй.
2. Хамтын ажиллагаа байхгүй.
3. Зөв бичгийн дүрмийн журамласан толь бичгээ мөрддөггүй.
4. Гадаад үгийг монгол хэлнээ хөрвүүлэх тогтсон дүрэм, стандарт байхгүй.
5. Орчуулж болох үгсийг шууд зээлдэн хэрэглэж байна гээд шийдлийг хэлэхдээ:
 1. Монгол хэлний үгийн санд орж ирсэн гадаад үгийг түүвэрлэн сан бүрдүүлэх
 2. Санд тулгуурлан гадаад үгийн хэрэглээ, хувилбар бичлэг, тухайн үгийн гарал, авиа зүйн талаар судлахаас гадна гадны сайн туршилагаас суралцах
 3. Монгол хэлний авиа зүйн онцлогт тохирсон тогтолцоотой дүрэм боловсруулах
 4. Журамласан дүрмийн дагуу гадаад үгийг журамласан толь бичигт зохиох
 5. Журамласан дүрэм бүхий толь бичгийг стандартчилан олон нийтэд мөрдүүлэх (Мөнхцэцэг, 2025) гэжээ.

Үг хурааж үүссэн нэр томъёог шууд зээлдсэн жишээ: *Fintech / финтек* – finance, technology хэмээх үгсийг хурааж бүтээсэн энэ үг нь мэдээллийн технологи, банк санхүүгийн салбар дундын нэр томъёо бөгөөд эдгээр үгсийг тус тусад нь монгол хэлнээ орчуулан хэрэглэдэг ч хураасан хэлбэрийг нь орчуулалгүй шууд галиглан хэрэглэж байна (Амартүвшин, 2023).

Proptech / проптек – property, technology хэмээх үгсийг хурааж үүсгэсэн энэ үг нь үл хөдлөх хөрөнгийг мэдээллийн технологитой холбож нийгмийн сүлжээгээр цахим орчинд арилжих менежментийн нэг төрөл болно. Үүнийг мөн адил үг тус бүрээр нь орчуулах боломжтой ч энэхүү хураасан хэлбэрийг нь үл хөдлөх хөрөнгийн зах зээл, мэдээллийн технологийн салбар дундын нэр томъёо болохын хувьд орчуулалгүй галиглан хэрэглэж байна.

Agritech / агритек – agriculture, technology хэмээх үгсийг хураахад үүссэн энэ үг нь хөдөө аж ахуй, мэдээллийн технологийн салбар дундын нэр томъёо бөгөөд эдгээр үгсийг тус бүрээр нь орчуулах боломжтой ч энэхүү хураасан хэлбэрийг нь салбар дундын нэр томъёо болохын хувьд орчуулалгүй галиглан хэрэглэж байна.

4.2. Мэргэжлийн үг, хэллэгийг нутагшуулахад гардаг түгээмэл бэрхшээл

Монгол хэлнээ харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үг, хэллэгийг нутагшуулах явцад олон бэрхшээл тулгарсаар ирсэн. Юуны өмнө, уг салбарын ихэнх ойлголт, ухагдахуун гадаад улсад үүсдэгээс шууд утга дүйцэх монгол үг олдохгүй байх асуудал элбэг тохиолддог. Үүний

улмаас нэр томьёог шууд галиглан хэрэглэх, эсвэл зэрэгцсэн олон орчуулга үүсэх байдал ажиглагддаг. Түүнчлэн орчуулсан, шинээр оноосон монгол нэр томьёо, мэргэжлийн үгс нь тайлбар шинжтэй, хэт урт хэрэглэхэд төвөгтэйгээс бодит хэрэглээнд тогтож чадалгүй гадаад хувилбараа хадгалах хандлага давамгайлж байна.

Нэг үгийн олон утгатай байдал: *Port, host, thread* гэх мэт үгс хам орчноос хамаарч утга шилждэг.

Орчуулгын олон хувилбар: Тухайлбал *interface*-ийг “интерфейс”, “харилцах талбар”, “дэлгэцийн холбоос” гэх мэтээр орчуулж байна.

Соёлын ялгаа: *Cookie, cash, firewall* зэрэг нь төрөлх англи хэлт хүмүүсийн соёл, сэтгэлгээнд суурилсан адилтгал тул үгчлэн орчуулахад монгол хүний сэтгэлгээнд тохиромж тааруу байдаг.

Стандартчилал сул: Монгол Улсын ХХМТ-ийн нэр томьёог оноох, түүнийг боловсруулахдаа нэр томьёо оноох стандарт баримтлаагүй. Салбар бүрийн нэр томьёог оноон, тогтооход тухайн мэргэжлийн стандартаас гадна хэл шинжлэлийн талаас нэр томьёо оноон боловсруулах ерөнхий буюу суурь стандарт байх ёстой бөгөөд ийм стандарт Монгол Улсад тухайн үед байгаагүй (2024 онд нэр томьёо оноох, боловсруулахад баримтлах ерөнхий зарчим болох MNS/ ISO 704: 2024-ийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбараас боловсруулан батлуулсан). Тиймээс хэдийгээр тухайн мэргэжлийн салбарууд тус бүрийн нэр томьёоны жагсаалтыг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлэн MNS стандарт авдаг ч шаардлага хангахгүй нэр томьёо их байдаг нь үүнтэй холбоотой. Доор ХХМТ-ийн салбарын жаргон, адилтгалаас орчуулснаа хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. ХХМТ-ийн салбарын жаргон

1	<i>урхидах</i>	<i>baiting</i>	Зорилтот этгээдийг сонирхолтой, үнэ төлбөргүй зүйл амлан татаж, хортой программ суулгах арга. Жишээ: “Та үнэгүй кино татаж авах эрхтэй боллоо!” гэх мэт холбоосыг ашигладаг (Cowlshaw, 1990).
2	<i>романс залилан</i>	<i>romance scam</i>	Романс залилан нь харилцаа холбооны хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд хуурамч хаяг профайл ашиглан хохирогчтой дотно харилцаа, хайр сэтгэлийн холбоо үүсгэх замаар төөрөгдөлд оруулж, хохирогчоос их хэмжээний мөнгийг нь залилан мэхэлж авах байдлаар үйлдэгддэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг юм.
4	<i>үүрүүлэх</i>	<i>piggybacking</i>	Хяналттай цахим орчинд зөвшөөрөлгүй этгээд хэн нэгний үйлдлийг дагаж орох.
5	<i>гэмт дайвар</i>	<i>payload</i>	Хэрэглэгчийг хуурч татуулах линк, вирус, эсвэл гэмт программ хангамж.
6	<i>тагнах эд</i>	<i>spyware</i>	Хэрэглэгчийн мэдээлэл, үйлдлийг нууцаар тандаж, гуравдагч этгээд рүү илгээдэг программ.
7	<i>үндэсний хэрээс</i>	<i>rootkit</i>	Үндсэн системд нууцаар сууж, халдагчид удирдлага өгөх, мөрдөх боломж олгодог программ хангамж.

8	логик бөмбөг	<i>logic bomb</i>	Тодорхой нөхцөл биелэхэд идэвхжиж хохирол учруулах программ код. Жишээ нь: Огноо, үйлдэл, хандалт зэргээр идэвхжинэ.
9	алсаас хандах троян	<i>rat (remote access trojan)</i>	Хэрэглэгчид мэдэгдэлгүйгээр компьютерыг алсаас удирдах боломж олгодог халдлага.
10	бот	<i>bot</i>	Өөрийн үйлдлээр халдлага үйлдэх (жишээ нь, DDoS) эсвэл сүлжээний нэг хэсэг болж хувирах программ.
11	зомби компьютер	<i>zombie</i>	Хяналтаа алдсан, хакерын удирдлагад орсон компьютер.
13	сэрээ	<i>fork</i>	Кодын хувилбар гаргах. Open-source төсөлд түгээмэл.
14	халуун засвар	<i>hotfix</i>	Программ хангамж, техник хангамжын алдааг шуурхай засах.
15	элсний хайрцаг	<i>sandbox</i>	Туршилтын орчин. Бодит системд нөлөөлөхгүйгээр туршилт хийх зориулалттай.
16	баярын өндөг	<i>easter egg</i>	Программ дотор зориуд нуусан хөгжилтэй элемент, нууц функц.
17	муйхарлалт	<i>brute force</i>	Нууц үг, кодыг таах оролдлогыг хүчээр олон дахин хийх.

Payload: Хэрэглэгчийг элдэв шагнал, ашиг олох сэдэл төрүүлсэн линкээр дамжуулан сүлжээнд холбогдсон хувийн төхөөрөмжийг тодорхой гэмт хэрэг, луйврын сэдлээр хакердах. Хүний аль нэг линк, сайтад нэвтрэхийг дагуулан программ суулгах үйлдэл. Payload-ийг үгчлэн орчуулахад “*төлбөртэй ачаа*” болох бөгөөд мөн ашигтай ачаа гэсэн утга агуулдаг. Үүнийг дээрх утгаар орчуулбал, тухайн ухагдахууныг илэрхийлж чадахгүй бөгөөд харин бүр эсрэгээрээ ойлгогдох эрсдэлтэй. Иймээс тус ухагдахууны онцлог шинжийг бүрэн дүүрэн илэрхийлэх, нэр томьёо онооход тавигддаг ерөнхий зарчмуудыг баримталбал, “*гэмт дайвар*” гэх нь зохимжтой гэж үзэж байна.

Romance scam: Сүүлийн үед Монгол Улсад энэ төрлийн гэмт хэрэгт хохирогсдын тоо маш их нэмэгдэж байгаа бөгөөд статистикийн үзүүлэлтээр эмэгтэйчүүд их өртжээ. “*Romance*” нь “*хайрын түүх*”, “*уянгалаг байдал*”, “*сэтгэл хөдлөл*” гэсэн үгстэй утга ойролцоо нэр үг бол “*romantic*” нь “*дурлалын*”, “*хайрын*”, “*сэтгэл хөдлөлтэй*” гэж дүйцэх тэмдэг нэр. Монгол хэлнээ “романтик” хэмээн орчуулалгүй хэрэглэх нь түгээмэл утгыг нь нийтээр ойлгодог. Үгийн гарлын хувьд дээрх үг нь латин хэлний *romanticus* (“*ромын*”, “*ромын иргэдийн*”) гэсэн үгнээс гаралтай. Дундад зууны үед хайр дурлалын сэдэвтэй яруу найраг, дуу, үргэлжилсэн үгийн зохиолыг энэ хэл дээр туурвих нь түгээмэл байснаар “*romance*” нь “*хайрын түүх*”, “*уянгын бүтээл, туурвил*” гэсэн утгатай болжээ. “*Romance scam*”-ийг “*дурлалын гэмт хэрэг*” гэж орчуулсан нь таарах нь бий. Цахим аюулгүй байдлын мэргэжлийн үг талаас энэ нь тус ухагдахууныг илэрхийлэхэд учир дутагдалтай гэж үзээд бид “*романс*” хэмээх үгийг хэвээр нь тодотгол болгож үлдээлээ.

Brute force: Энэ нь нууц үг, кодыг таамгаар олон дахин хийх үйлдлийг нэрлэсэн жаргон юм. “Brute” = зэрлэг, бүдүүлэг, “force” = хүч. Эндээс бид “brute force”-ийг энгийн хэлний хэрэглээнд “харгис хүч”, “балмад хүч” зэргээр орчуулж болно. Харин энэхүү жаргоныг ХХМТ-ийн салбарын хэрэглээний хүрээнд нэр томъёоны ухагдахуун илэрхийлэх, нэр томъёо оноох зарчмыг баримтлан орчуулбал “*муйхарлалт*” гэх нь товч бөгөөд оновчтой болно.

ХХМТ-ийн салбарт амьтны шинж чанарын онцлогоор нэрлэсэн адилтгал, зүйрлэл их түгээмэл байдаг. Тэдгээрээс орчуулснаа доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. ХХМТ-ийн салбарын амьтны нэртэй адилтгал (метафор)

Англи	Монгол	Тайлбар
worm	өм	Сүлжээгээр өөрийгөө хуулбарлан тараадаг хортой програм. Хэрэглэгчийн оролцоогүйгээр тархдаг (Rigdon, 2016)
spider	аалз /вэб мөлхөгч	Вэб сайтуудаар мөлхөж, мэдээлэл цуглуулдаг бот. Хайлтын системээр дамждаг.
sniffer	сүлжээ үнэрлэгч	Сүлжээгээр дамжиж буй мэдээллийг тагнаж, хулгайлах хэрэгсэл
cat (unix command)	муур команд	Файлын дотоод агуулгыг харуулах команд (cat filename.txt).
rabbit mq	мессеж дамжуулах хэрэгсэл	Мессеж дамжуулах тогтолцоо. Программ хооронд мэдээлэл солилцох боломж олгодог
octopus deploy	наймаалжсан байрлал	Автоматжуулсан программ хангамж байршуулалтын хэрэгсэл
honeypot	зөгийн балтай хавх	Хакеруудыг татах зорилготой хуурамч систем. Аюулыг илрүүлэх, судлахад ашиглана.
phishing	загасчлах	Хуурамч и-мэйл, вэб сайтаар дамжуулан хэрэглэгчийн хувийн мэдээллийг хулгайлах арга
crabby code	хавчны код	Адармаатай бичлэгтэй код
zombie	зомби компьютер	Хакерын удирдлагад орсон, халдлагад ашиглагдаж буй компьютер (Douglas A. Downing, Michael A. Covington, 2009)
bug bounty	цохны баунти	Программ хангамжийн алдаа (bug) илрүүлсэн хүмүүст компаниас өгдөг шагнал. "Bounty" нь дотроо коксын самрын зөөлөн эд агуулсан нэгэн төрлийн шоколадны нэр болно.
trojan horse	трояны морь	Мэдээллийн технологийн салбарт "трояны морь" хэмээх нэр нь нэгэн төрлийн гэмт программыг илэрхийлдэг. Системд нэвтэрсэн тохиолдолд нэгээр тогтохгүй гэмт үйлдлүүд гүйцэтгэдэг. Жишээ нь: Мэдээлэл хулгайлах, хэрэглэгчийн үйлдлийг хянах, хууль бус сайт руу зөвшөөрөөгүй хандалтыг хийлгэх гэх мэт. Компьютерын вирусээс ялгаатай нь троян өөрийгөө хувилан олшруулах, өөрөө идэвхтэйгээр ажиллах үйлдэл хийдэггүй. Үүний оронд хэрэглэгчийн оролцоот үйлдлүүдээр халхлагдан давхар хандалт хийдэг. Энэ төрлийн программыг "троян" эсвэл "трояны морь" гэж нэрлэсэн шалтгаан нь хэрэглэгч программ суулгах үед түүний нэг хэсэг мэтээр далдлагдан системд нэвтэрдэг нь эртний Грекийн домогт гардаг дотроо цэргүүд нуусан том модон морьтой ижил байдгаас үүдэлтэй.

Phishing: Интернет орчин дахь хэрэглэгчийн нууц мэдээллийг хуурч мэхлэн авах зорилготой кибер халдлага. Англи хэлний “*fishing*” (загас барих) гэх үгээс метафор байдлаар гарсан. Эхний “f” үсгийг “ph” гэж бичсэн нь “*phreaking*” (утас, телеком сүлжээнд нэвтэрч хууль бусаар ашиглах) зэрэг хакер / крэкер үйлдлийг илэрхийлэхэд түгээмэл хэрэглээтэй өөрөөр хэлбэл хакер/фриктэй холбоотой үгсэд “ph”-г зориуд оруулдаг дадлын үндсэн дээр “*phishing*” үг үүсжээ. Жишээ нь: *phreaking* (phone + freak гэсэн утгатай гарч ирсэн үгсийн нэг хэлбэр) — утасны систем рүү нэвтэрч гэмт үйлдэл хийхтэй холбоотой нэршил юм.

Хэрэглэгчдийн сэтгэлгээнд нөлөөлж,элдэв холбоосоор хууран татаж хохироох үйлдлийг “*өгөөш үмхүүлж загас барих*” (*fishing*) гэсэн метафороор зүйрлэснийг “*урхидах*”, “*загасчлах*”, “*загас барих*”, “*өгөөш үмхүүлэх*” гэх мэт олон хувилбараар мөн шууд галиглан “*фишинг*” гэж хувилбараар орчуулж байгааг бид энд “*гэхийдэх*”¹ гэж хуучин мартагдсан үгийг шинээр нэр томьёо онооход шууд болон ойролцоо утгаар хэрэглэдэг зарчмыг баримтлан орчууллаа.

Дүгнэлт

Монгол Улсын Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн үгийн сан их эртнээс бүрэлдэн тогтжээ. Хүннү, Их Монгол, Юань гүрэн дамнан Богд хаант Монгол Улс хүртэлх түүхэн цаг хугацааг туулан аман болон бичгийн өв, баримтад дурдагдаж ирсэн “*зам*”, “*өртөө*”, “*улаач*”, “*дохиоч*”, “*утаат дохио*”, “*гэрэгэ*”, “*зарлага мэдээ*”, “*уяачин*”, “*тай*” зэрэг үгс нь илэрхийлж буй ухагдахуун талаасаа мэргэжлийн салбарын нэр томьёоны үүргийг гүйцэтгэж байжээ.

Орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн технологи нь Европын шинжлэх ухаан Манж Чин гүрэнд нэвтрэх үед XIX зууны сүүл үеэс монголчуудын хэрэглээнд нэвтэрч эхэлсэн бол XX зууны эхэн дунд үеэс Зөвлөлт Холбоот улсын техник технологийг хэрэглэх явцад эхэндээ мэргэжлийн үгсийг орос хэлнээс орчуулалгүй шууд зээлдэн (“*радио*”, “*станц*”, “*монтёр*”) аажмаар “*радио долгион*” гэх мэт холимог үг үүсгэн, “*цагийн давтамж*”, “*долгионы үелзэл*”, “*цахилгаан шуудан*”, “*цахилгаан илгээх*” хэмээн үгчлэн орчуулж байсан бол 1990 оноос хойш англи хэлний нөлөө давамгайлж, интернэт, мобайл технологийн үсрэнгүй хөгжлийн нөлөөгөөр “*файл*”, “*сервер*”, “*браузер*”, “*app*”, “*драйвер*” гэх мэт үгсийг эхэндээ англи хэлнээс шууд зээлдэн галиглан хэрэглэж яваандаа үгчлэх (“*үүлэн тооцоолол*”), утгачлах (“*тоон шилжилт*”, “*нээлттэй өгөгдөл*”), дүйцүүлэх, шинэ үг бүтээх, холимог үг бүтээх зэрэг бүх аргыг хавсран орчуулж байна.

Мэргэжлийн үг, хэллэг тогтмол хувьсан өөрчлөгдөж байдаг зүйл билээ. Өнөөдөр хүний нийгмийн харилцаа цахим орчинд мэдэгдэхүйц шилжиж буйгаас хамаараад нийгмийн цахим сүлжээ, ХХМТ-ийн үг, хэллэг хурдтай нэмэгдэж “*аппликейшн*”, “*дата*”, “*сим карт*” гэх мэт үгсийг олон улс, үндэстний хэлэнд

¹ “Гөхий”- гох, дэгээ бүхий загас агнах хэрэгсэл” (Ш.Чоймаа, 2011)

ижил утгаар хэрэглэх болсон нь эсперанто хэлний үүрэг, зорилгыг ХХМТ-ийн мэргэжлийн хэл орлох бололцоотойг харуулж байна. Глобал шинжтэй мэргэжлийн үгс нь нэг талаас үгийн санг баяжуулж, нөгөө талаас олон хувилбар үүсгэн эмх цэгцгүй болгожээ.

“Сервер/сервэр”, “браузер/брауэр”, “кабель/кабел”, “софтвер/софтвэр” гэх мэт олон хувилбарт бичлэгүүд нь хэлний бодлого, эрх зүйн орчин, стандарт, журам дутмаг байгааг харуулж байна. Жишиг болгох латин-кирилл хөрвүүлгийн стандарт, мэргэжлийн зөвлөмж, журамласан толь бичгийг шинээр боловсруулах шаардлагатай болжээ.

ХХМТ-ийн мэргэжлийн үг, хэллэг нь монгол хэлний үгийн сангийн хөдлөмтгий, хувьсамтгай хэсэг болсон бөгөөд энэ нь технологийн өөрчлөлттэй шууд уялддаг онцлогтой. Монгол хэлний уламжлалт мэргэжлийн үгсийг дэлхийн технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн хэрэглэж, оновчтой сонгож журамлах, ард иргэдийн мэргэжлийн хэлний чадварыг сайжруулах, салбар хоорондын ойлголтын зөрүүг арилгах зэрэг нь нэн түрүүнд авах арга хэмжээ юм.

ХХМТ-ийн мэргэжлийн үг, хэллэгийн судалгаа нь зөвхөн хэл шинжлэлийн ач холбогдолтой бус, хэлний бодлого боловсруулах, шинжлэх ухаан, боловсрол, эдийн засаг, бизнесийн орчинд шууд хэрэгцээтэй суурь мэдлэг болно.

Ном зүй

- Амартүвшин, Н.** (2023). Финтек. Н. Мөнхцэцэг, Н. Амартүвшин, Г. Гэрэлмаа, Т. Батбямба, Б. Золжаргал, & Х. Гэндэнпил-Д, *Үгийн учир IV* (хууд. 148). Улаанбаатар: Соёмбо принтинг. [Amartüvshin, N. (2023). Fintyek. N. Mönkhtsetseg, N. Amartüvshin, G. Gerelmaa, T. Batbyamba, B. Zoljargal, & Kh. Gendenpil-D, *Ügiin uchir IV* (khuud. 148). [Meaning of the words IV]. Ulaanbaatar: Soyombo printing. 2023]
- Мөнхсайхан, С.** (2024). *“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-ны эрдэм шинжилгээний хөрвүүлэг*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mönkhsaikhаn, S. *"Mongolyn nuuts tovchoo"-ny erdem shinjilgeenii khörvüüleg*. [Scientific transcription of “The Secret History of the Mongols”]. Ulaanbaatar: Soyombo printing. 2024]
- Мөнхсайхан, С.** (2023). *“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-ны утга зүй, соёл, сэтгэлгээ*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mönkhsaikhаn, S. *"Mongolyn nuuts tovchoo"-ny utga züi, soyol, setgelgee*. [Mentality, Culture, Semantics of “The Secret History of the Mongols”]. Ulaanbaatar: Soyombo printing. 2023]
- НЭПКО.** (2019). *Монголын харицаа холбоо түүхийн альманах*. Улаанбаатар: НЭПКО. *Mongolyn khariltsaa kholboo tüükhiiin alimanakh*. [Historical Almanac of Mongolian Communication sector]. Ulaanbaatar: NEPKO. 2019]
- Томтогтох, Г.** (2012). *Хэл шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Tomtogtokh, G. *Khel shinjileiin udirtgal*. [Introduction of Linguistics]. Ulaanbaatar: Soyombo printing. 2012].

- Төмөрхүү, Н; Намсрай, Н.** (2011). *Монгол Улсын шуудангийн түүхэн товчоо*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Tömörkhüü, N; Namsrai, N. *Mongol Ulsyn shuudangiin tүүkhen товchoo*. ["A Concise History of Postal Services in Mongolia"]. Ulaanbaatar: Mönkhiin üseg. 2011]
- Чоймаа, Ш.** (2011). *“Монголын Нууц Товчоон” (Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг)*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.[Choimaа, Sh. *“Mongolyn Nuuts Tovchoon” (Ertnii үг khellegiin түгеемел тайлбартai shine khörvүүleg)*. [“The Secret History of the Mongols”(New transcription with multipurposal explanation of archaic word, phrases)]. Ulaanbaatar: Mönkhiin üseg. 2011]
- ӨМХУЗТСГ** (1977). *“Хорин нэгт тайлбар толь”*. Хөх хот: Өвөрмонголын Монгол хэл, утга зохиол, түүх судлалын газар. [ÖMKhUZTSG. *“Khorin negt тайлбар толи”*. [Explanatory dictionary 21]. Khökh khot: Övörmongolyn Mongol khel, utga zokhiol, түүх судлалын газар. 1977]
- Cowlishaw, M.** (1990). *IBM Jargon and General Computing Dictionary*. Winchester: IBM UK Laboratories.
- Dor, D.** (2015). *Language as a Social Communication Technology*. Oxford: Oxford University Press.
- Douglas A. Downing, Michael A. Covington.** (2009). *Dictionary of Computer and Internet terms*. New-York: Barron's.
- Kemp, S.** (2025). *The Essential Guide to the World's Connected Behaviours Digital 2025* . London: Meltwater.
- Rigdon, J. C.** (2016). *Dictionary of Computer and Internet Terms*. Cartersville: Eastern Digital Resources.

Цахим холбоос:

- Мөнхцэцэг, Н.** (2025). *Англи үг, оноосон нэрийг кириллээр хөрвүүлэх асуудал - Олон янзаар бичиж буй гадаад үгийг зөв бичих стандартын тухай хэлэлцлээ*. [Mönkhtsetseg, N. *Angli үг, оноосон нерийг kirilleer khörvүүlekh asuudal - Oлон yanzaar bichij bui gadaad үгийг зөв bichikh standartyn tukhai kheleltslee*. [The Issue of Transliterating English Words and Proper Names into Cyrillic - A Discussion on Standards for the Correct Spelling of Foreign Words Written in Multiple Ways] <https://montsame.mn/>: <https://montsame.mn/mn/read/379540>
- Mongoltoli.mn.** (*Монгол хэлний их тайлбар толь*.[*Mongol khelniiikh тайлбар толи*. [Comprehensive explanatory dictionary of Mongolian] <https://mongoltoli.mn/dictionary/detail/82434>
- ЦХИХХЯ.** (2025, 7 25). <https://mddic.gov.mn/> . Retrieved 7 25, 2025, from <https://mddic.gov.mn/>: <https://mddic.gov.mn/eng/2025/07/21972/> <https://www.zindaa.mn/4gy4>